

**“ТАЙШАНШИН ЮАНЬ” ХХК**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ДАЙ-УУЛЫН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2023он**

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН ДАРГА

Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ТАЙШАНШИН ЮАНЬ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

GUAN JIAO MEI

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ДАЙ-УУЛЫН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Регистрийн дугаар: 5103851

ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАСАН:

ХБОБНУГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

СОЛОНГО

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

“ХАС ЦАГ” ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

Н.ОЮУНТУУЛ

**УЛААНБААТАР ХОТ 2024 ОН**

ГАРЧИГ	
Оршил .....	2
<b>НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....</b>	<b>3</b>
1.1 Төслийн байршил.....	3
1.2 Төслийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж .....	4
<b>ИЛ УУРХАЙН АЖИЛЛАХ ГОРИМ.....</b>	<b>4</b>
<b>ИЛ УУРХАЙН ХҮРЭЭ ХЯЗГААР, ТҮҮНИЙ ХҮРЭЭН ДЭХ ХӨРС ХҮДРИЙН ХЭМЖЭЭ, АШИГЛАЛТЫН НӨӨЦ.....</b>	<b>5</b>
<b>ИЛ УУРХАЙН УУЛЫН АЖЛЫН КАЛЕНДАРЬ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>6</b>
<i>АШИГЛАЛТЫН СИСТЕМ.....</i>	<i>6</i>
<i>Уурхайн дотоод тээвэр.....</i>	<i>7</i>
<b>ӨРӨМДЛӨГ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ.....</b>	<b>7</b>
1.4. Усан хангамж .....	8
1.5. Цахилгаан хангамж .....	8
<b>ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>12</b>
<b>2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>13</b>
2.1.1 Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ.....	13
2.2 Усан орчин хамгаалах арга хэмжээ .....	15
2.3. Хөрс, ургамал хамгаалах арга хэмжээ.....	17
<b>ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>17</b>
<b>ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>20</b>
<b>ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>21</b>
<b>ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>21</b>
<b>ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>22</b>
<b>НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>23</b>
<b>ЁС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>25</b>
<b>АРАВ.ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....</b>	<b>29</b>
<b>11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....</b>	<b>29</b>

## **ОРШИЛ**

“Тайшаншин Юань” ХХК-ийн Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Дай-Уулын хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглан флотацийн аргаар баяжуулах төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед дагаж мөрдөх байгаль хамгаалах төлөвлөгөө орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших Дай-Уулын хайлуур жоншны ордод 2012 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” /Ордын нөөц 2014 оны 07-р сарын 09-ний байдлаар/ дахь MV-012412 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах хайлуур жоншны хүдрийн бодитой (В) зэргийн нөөцийг 1532.93 мян.тн-оор 33.44% дундаж агуулгатай CaF<sub>2</sub>-ын нөөцийг 512.56 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн боломжтой (С) зэргийн нөөцийг 2973.49 мян.тн-оор 32.82% дундаж агуулгатай CaF<sub>2</sub>-ын нөөцийг 975.94 мян.тн-оор, ордын хэмжээнд хайлуур жоншны хүдрийн нийт бодитой, боломжтой /В+С/ нөөцийг 4506,22 мян.тн хайлуур жоншны /В+С/нөөцийг 1488,5 мян.тн-оор 2014 оны 08 сарын 04-ний өдрийн Ашигт малтмалын газрын даргын н-132 дугаар тушаалаар Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

Тус уурхай нь 1-р хүдрийн биетийг ил ба далд аргаар 15 жил ашиглах ба ил уурхай ашиглалтын эхний 1-4 дэх жилд 705.68 мян.тн хүдэр, 2,27сая.м<sup>3</sup> хөрс хуулалт, далд уурхай үндсэн болон бэлтгэл малталтуудыг 4 дэх жилээс эхлэн нэвтэрч бэлдсэний дараа ашиглалтын 5-15 дахь жилд далд уурхайгаас 1107,99мян.тн хүдэр олборлоно. Нийт ил далд уурхайгаас 1 813,67 мян.тн 33.03%-ийн агуулгатай хүдэр олборлохоор төсөлд тусгасан байна.

Дорноговь аймгийн Айраг сумын нутаг орших “Дай-Уулын хайлуур жоншны хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах флотацийн аргаар баяжуулах” төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Ляпислазурь эрдэнэ” ХХК холбогдох стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

## НЭГ. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 Төслийн байршил


Засаг захиргааны хувьд Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт Дай-Уул нэртэй газар байрладаг.

Орд нь газар нь физик-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Дорнод Говийн мужид хамаарах Дорноговийн хотгорын тойрогт хамаарах ба Улаанбаатар хотоос 310км-т, Бор-Өндөрийн жоншны ордоос урагш 25км Айраг өртөөнөөс зүүн хойш 30км-т, Чойроос зүүн урагш 100км-т, Сайншандаас баруун хойш 135км зайд оршино.

MV-012412 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ нь 100га Ордын газарзүйн солбилцол нь :

Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбилцол нь: L-49-60		
1	109° 32' 52.45"	46° 01' 01.64"
2	109° 32' 18.26"	46° 01' 01.64"
3	109° 32' 18.26"	46° 01' 45.64"
4	109° 32' 52.46"	46° 01' 45.64"





Зураг 1. Ашиглалтын талбайн байршлын байрзүйн зураг

## 1.2 Төслийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж

ЭБМЗ-ийн 2020 оны 07-р сарын 09-ны Т/20-10-04 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2020 оны 08-р сарын 24-ны т/148 тоот тушаалаар хүлээн авсан ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог блокийн аргаар боловсруулсан байна. Цаашид үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ТЭЗҮ-д тусгагдасны дагуу тооцоолон төлөвлөсөн. 2024 оны олборлолтын үеийн дундаж бохирдол 3.418 %, хаягдал 4.89 % - тайгаар олборлоно

2024 онд 1050-1030 түвшингийн /1-В-1, 1-В-2, 1-С-7, 1-С-8, 16-С-1/ блокуудыг олборлон 96.480 мян.тн хүдрийг /хүдэр дэх металлын хэмжээ 30583.5 тн/ олборлоно. 2024 онд 410.71 мян.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэнэ.

### Ил уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн турш хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төлөвлөлөө. Жилийн нийт хоног

	365 хоног
- Үндэсний баяр, ёслолын хоног	15 хоног
- Өвлийн улирлын сул зогсолт	135 хоног
- Засвар үйлчилгээ	15 хоног
- Цаг агаарын нөхцлийг тооцсон хоног	15 хоног
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног	170 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо	2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	12 цаг тус тус байна.

**Ил уурхайн хүрээ хязгаар, түүний хүрээн дэх хөрс хүдрийн хэмжээ, ашиглалтын нөөц**

Ил уурхай нь зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон ба ил уурхайн амсрын өргөн 225м, урт 495м, уурхайн ёроолын өргөн 50м, урт 240м байна. Ил уурхайн нээлтийн траншейн эхлэл цэгийн солбицол  $x=5098096.1$  ,  $y=389431.3$  байна.

**Хүснэгт 1. Ил уурхайн хил хязгаар доторхи геологийн нөөц**

Түвшин	Уулын цул	Хөрс	Хүдэр		Хөрс хуулалтын коэффициент		Агуулга CaF <sub>2</sub>	Жонш
	м <sup>3</sup>		м <sup>3</sup>	м <sup>3</sup>	тн	м <sup>3</sup> /м <sup>3</sup>		
1055-1060	9062	8040	1022	2656	9.89	3.03	33.08	899
1050-1055	49994	43462	6312	16409	6.89	2.65	32.45	5324
1045-1050	141920	131336	10584	29515	12.41	4.99	31.95	8991
1040-1045	309909	295494	12213	31953	24.20	9.31	31.25	9923
1035-1040	299462	266856	12606	32992	21.19	8.14	30.38	9958
1030-1035	261055	248001	13054	33939	19.00	9.31	30.04	10194
1025-1030	242999	228649	14330	39255	15.96	6.14	30.09	11208
1020-1025	225160	208958	16202	42122	12.90	4.96	29.98	12628
1015-1020	194590	195332	19258	50069	9.10	3.50	30.03	15038
1010-1015	199002	155262	21940	56523	9.14	2.95	30.19	19063
1005-1010	158593	128419	30194	98449	4.26	1.64	31.32	24590
1000-1005	138149	99122	39025	101465	2.54	0.98	32.95	33226
995-1000	108164	92014	36150	93989	1.99	0.99	33.56	31544
990-995	90949	61986	29161	95815	2.12	0.81	32.99	24859
985-990	53429	29092	24335	63269	1.20	0.46	32.61	20633
980-985	39100	16329	22993	59209	0.92	0.28	33.25	19689
<b>Нийт</b>	<b>2499089</b>	<b>2168148</b>	<b>308939</b>	<b>803209</b>	<b>9.02</b>	<b>2.90</b>	<b>31.81</b>	<b>255524</b>

**Уурхайн хаягдал, бохирдолтын тооцоо**


Ил уурхайн хүдрийн хаягдал 5.4%, бохирдолт 3.5% тус тус байхаар ТЭЗҮ-д тусгасан байна.

**Хүснэгт 2 .Ил уурхайн хүрээн дэх ашиглалтын нөөц**

Түвшин	Хаягд ал	Бохир дол	Уулын цул	Хөрс	Хүдэр		Агуулг а CaF <sub>2</sub>	Жонш	Хөрс хуулалтын коэффициент	
	%	%			м <sup>3</sup>	м <sup>3</sup>			м <sup>3</sup>	тн
1055-1060	5.4	3.5	9062	8061	1001	2601	31.93	830	8.06	3.10
1050-1055	5.4	3.5	49994	43594	6180	16064	31.31	5030	9.05	2.91
1045-1050	5.4	3.5	141920	131559	10363	26940	30.83	8306	12.90	4.88
1040-1045	5.4	3.5	309909	295949	11958	31090	30.16	9396	24.93	9.51
1035-1040	5.4	3.5	299462	269119	12343	32089	29.32	9408	21.64	8.32
1030-1035	5.4	3.5	261055	248294	12981	33230	28.98	9631	19.42	9.49
1025-1030	5.4	3.5	242999	228946	14031	36499	29.03	10590	16.32	6.28
1020-1025	5.4	3.5	225160	209296	15864	41242	28.93	11932	13.19	5.09
1015-1020	5.4	3.5	194590	195934	18856	49023	28.98	14208	9.32	3.58
1010-1015	5.4	3.5	199002	155916	21286	55342	29.13	16122	9.32	2.81
1005-1010	5.4	3.5	158593	129049	29544	96810	30.22	23215	4.39	1.68
1000-1005	5.4	3.5	138149	99939	38210	99345	31.60	31394	2.62	1.01
995-1000	5.4	3.5	108164	92969	35395	92026	32.39	29804	2.06	0.99
990-995	5.4	3.5	90949	62395	28552	94231	31.64	23488	2.19	0.84
985-990	5.4	3.5	53429	29600	23829	61949	31.49	19494	1.24	0.48
980-985	5.4	3.5	39100	16803	22299	59992	32.09	18601	0.95	0.29

Түвшин	Хаягдал	Бохир дол	Уулын цул	Хөрс	Хүдэр		Агуулга Сагз	Жонш	Хөрс хуулалтын коэффициент	
	%	%			М <sup>3</sup>	ТН			М <sup>3</sup> /М <sup>3</sup>	М <sup>3</sup> /ТН
Нийт	5.4	3.5	2499089	2194602	302485	986428	30.90	241429	9.19	2.99

Зураг 2. Дай Уулын ордыг ашиглах ил уурхайн ажлын дэвсгэр зураг



### Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө

2024 онд 1050-1030 түвшингийн /1-B-1, 1-B-2, 1-C-7, 1-C-8, 16-C-1/ блокуудыг олборлон 96.480 мян.тн хүдрийг /хүдэр дэх металлын хэмжээ 30583.5 тн/ олборлоно. 2024 онд 410.71 мян.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэнэ.

### Ашиглалтын систем

Хайлуур жоншны хүдрийн ил уурхайд хөрс хуулалт, болон хүдэр олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ, экскавацлалт, автотээвэр гадаад овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн агуулах хүртэл тээвэрлэн байрлуулна.



**Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ил уурхай
1	Ил уурхайн гүн	м	40-65
2	Ил уурхайн амсрын урт	м	460
3	Ил уурхайн амсрын өргөн	м	110-250
4	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	34-47
5	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр	м	5
6	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	м	5
9	Доголын налуугийн хэмжээ	градус	65
8	Ажлын бус доголын аюулгүйн өргөн	м	3
9	Ажлын доголын аюулгүйн өргөн	м	2
10	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	50
11	Ажлын талбайн өргөн	м	30

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авахаар энэхүү төсөлд тусгалаа. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 2.5м<sup>3</sup>-ийн утгуурын багтаамжтай HYUNDAI-500-LC-9 маркийн урвуу утгуурт экскаватор
- 90 кВт -ийн хүчин чадалтай SHANTUI фирмийн SD13 маркийн бульдозерууд
- 40 тн даацтай YTK-63 маркийн автосамосвалууд
- 140 мм-ийн диаметртэй JK590 маркийн өрмийн машинууд
- 3 м3 -н шанаганы багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч
- Туслах машин механизм (үйлчилгээний машинууд г.м.)

**Уурхайн дотоод тээвэр**

Ил уурхайн технологийн автотээвэр нь уурхайн хөрөнгө оруулалтын 50-60% ашиглалтын зардлын 90 хүртэлх хувийг эзэлдэг үйлдвэрлэлийн хөрөнгө, хөдөлмөр зарцуулалт хамгийн ихтэй үндсэн процессуудын нэг юм. Энэхүү ил уурхайд 15-20тн-н даацтай автосамосвалуудыг ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна.

**Хүснэгт 5. Ил уурхайд шаардлагатай автосамовалын тоо**

№	Ашиглалтын жилүүд	хэмжих нэгж	1
1	Хөрс хуулалт	мян.м <sup>3</sup>	452.99
2	Хүдэр олборлолт	мян.тн	198.49
3		мян.м <sup>3</sup>	41.51
4	Автосамосвалын жилийн бүтээл (хөрс)	мян.м <sup>3</sup>	159.39
5	Автосамосвалын жилийн бүтээл (хүдэр)	мян.тн	488.06
6	Автосамосвалын тооцооны тоо (хөрс)	шир	2.84
9	Автосамосвалын тооцооны тоо (хүдэр)	шир	0.39
8	Парк ашиглалтын коэффициент		1.2
11	Нийт (HOWO)	шир	4

**Өрөмдлөг, тэсэлгээний ажил**

Ил уурхайд 150мм-ийн диаметртэй БНХАУ-д үйлдвэрлэсэн Glorytek брендийн JK358N маркийн өрмийн машиныг ажлуулахаар тусгасан байна. Уурхайд тэсрэх бодис (АНФО) хэрэглэх ба хэрэглэх хэмжээг доор хүснэгтээр үзүүлээ.

	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хөрс хуулалт	Хүдэр олборлолт	Нийт
1	Нийт шаардлагатай тэсрэх бодисын хэмжээ	тн	268.09	23.85	291.94
2	Нийт өрөмдлөгийн урт	мян.м	29.87	2.66	32.53
3	Нонель систем	ш	4978	443	5421
4	Цочир дамжуулах шижим	м	24892	2215	27107
5	Реле	ш	3319	295	3614
6	Өдөөгч	ш	4978	443	5421
7	Цахилгаан тэслүүр	ш	293	112	406

#### 1.4. Усан хангамж


Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах "Тайшаншин юань" ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд “Хөл сая” ХХК-ийн өрөмдөж гаргасан гүний худагаас үйлдвэрийн усны хэрэгцээг хангана. Тус худагууд нь 0.8-11,0л/с ундаргатай гэж тогтоогдсон байна.

#### Ил уурхайн усны хэрэглээ

Ил уурхайд уурхайн талбай, замын тоосжилт дарах зорилгоор ус хэрэглэнэ. Ил уурхайн тоосжилт дарахаар хэрэглэх усны хэмжээ нь ил уурхай болон бусад хэрэглээнд нийт 4590м<sup>3</sup> ус хэрэглэхээр байна.

#### 1.5. Цахилгаан хангамж

Ил уурхай цахилгаан хэрэглэгчдийг найдвартай эх үүсвэрээс хангахын тулд Дорноговь аймгийн Айраг сумын 110/35кВ-ын дэд станцаас Дай-Уулын орд хүртэл 30км цахилган 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж төвийн эрчим хүчний нэгдсэн системээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгаж байна.



Гадаад цахилгаан хангамж схем

## БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов.

Төслийн үйл ажиллагааны улмаас газрын доорх ус хомсдох, чанарт нь өөрчлөлт орох, хөрсний бүтэц, бүрэлдэхүүн, геологийн тогтоц, агаарын төлөв байдал өөрчлөгдөх, ургамал нөмрөг багасах, эрдэс баялгийн төрөл, хэмжээ хомсдох, малын бэлчээрийн талбай устгах, агаарын бохирдол, ландшафтын хэлбэр, байгалийн өнгө төрх өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх дуу шуугиан, уурхайг олборлолтын улмаас зэрлэг амьтад дайжих зэрэг сөрөг нөлөөллүүд байж болохын зэрэгцээ орон нутгийн дэд бүтэц сайжрах, орон нутгийн орлого нэмэгдсэнээр ядуурлын түвшинг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөллүүд байна.

#### Гол сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, үргэлжлэх хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Шимт хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
2	Олборлолт	Геологийн тогтоц, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
3	Тээвэр	Хөрс, агаар	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
5	Ус ашиглалт	Гүний ус	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд

Төслөөс тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсэний дараа ч сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Сөрөг нөлөөллийн эрчим нь олборлолт эхэлсэнээс хойш ихсэнэ. Төслийн үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, агаарын чанар, гүний усны хэмжээ, чанар өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

#### Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал

Уурхайн үйл ажиллагааны улмаас 2024 онд ил уурхай, үйлдвэр, зам, хөрсний овоолго зэрэг талбайг хамарсан эвдрэл үүсч байгаль орчинд сөрөг нөлөө учруулна. Ордыг ашигласнаар газрын гадаргууг тодорхой хэсэгт өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, гидрогеологийн горимыг өөрчилдөг.

#### Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Төслийг ордыг олборлох, бутлах, тээвэрлэх явцад машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий гэх мэт/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын хими болон физик шинж чанарт нь сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.

Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

### ***Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл***

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Ил уурхайн хил хязгаар дотор Ухаагийн битумжсан ордыг олборлоход “2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний тайланд тусгаснаар хөрсний бүтэц, үржил шимт чанарыг алдагдуулна.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана
- Хүдрийг тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших

### ***Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл***

- Унд ахуйн болон технологийн усны хэрэглээг өөрсдийн талбайд байрлах гүний худагаас хангана гэж “2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний тайланд тусгажээ. Энэ нь газрын гүний усны нөөц, горимд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.
- Аадар борооны үед тус талбайн хойд болон зүүн талаас түр зуурын үерийн ус бууж талбай дахь хөрс, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

### ***Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл***

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

### ***Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт нөлөөлөх нөлөөлөл***

Ухаагийн битумжсан ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс, үүний хамтаар, уурхайн үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшсэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм. Иймд төслийн талбайг эзэмших, уурхайн үндсэн ба туслах үйл ажиллагааг эхлэх хугацаа, горимыг дээрх нөхцөл байдалтай уялдуулан нарийн төлөвлөх, орон нутгийн ан амьтан хамгаалах, малчдын

нөхөрлөл, санаачлагуудтай, шаардлагатай гэж үзвэл, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч уулын ажлын үед дагаж мөрдөх хамтарсан төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд :

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр удирдан хязгаарлах нь нутгийн газар ба хөрс, ургамал, амьтдыг хамгаалах нэгэн төрлийн арга хэмжээ болно.

Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх зүйлүүдийн тоо өсөх магадлалтай.

#### ***Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл***

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖСайдын 2024 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, гөзрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймаг нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Улирлын чанартай ажилладаг уурхайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.

**Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр:** Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

### БОМТ зардлын нэгтгэл

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тухайн жилд мян.төг
1	Агаар орчин	3562,0
2	Усан орчин	2800,0
	Хөрс ургамалан бүрхэвч	2260,0
2	Удирдлага зохион байгуулалт	2250,0
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2000,0
4	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	3950,0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	8000,0
6	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1000,0

7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	<b>1450,0</b>
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	<b>1000,0</b>
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<b>1892,0</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>27864,2</b>

## **1.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **2.1.1 Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед болон овоолго, уурхайн догол, мөрөгцөгүүд, автотээврийн зам, өрөмдлөг, тэсэлгээ зэргээс салхины үйлчлэлээр тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг. Хавар, намрын хуурайшилттай улиралд салхины хурд 15-20 м/с хүртэл ширүүсэх үед тоосжилт бууруулах арга хэмжээ авах зорилгоор шүүрүүлийн усаар чийглэж дор дурдсан арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

Утгуурт ачигчын ажлын үед:

Ажлын талбай болон мөрөгцөгийг услах

Утгуурт ачигчын кабиныг битүүмжилж тоос шүүх агааржуулагч төхөөрөмжөөр тоноглох

Утгуурт ачигчын кабиныг чийгтэй алчуураар цэвэрлэж байх

Авто зам:

Дулааны хуурайшилттай үед уурхайн дотоод болон гадаад замыг услах

Олон салаа зам гаргахгүй байх

Овоолго болон жалга:

Овоолсон хаягдал чулуулгийг ил аргаар ашиглах үед үлдэх карьерт зураг төслийн дагуу дүүргэлт хийж нөхөн сэргээх

Биологийн нөхөн сэргээлт хийх

Хорт хийг бууруулах:

Хүнд машин, механизмуудын удаан хугацаагаар асаалттай орхихгүй байх

Машин, механизмын янданд шүүлтүүр тавих

### **АГААРЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨМЖ:**

- Автотээврийн улсын үзлэг оношлогоог хийлгэж хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд хөдөлгүүрийн утааны тортогжилтын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийх, эсхүл ашиглалтаас гаргах,

- Уурхайн нутаг дэвсгэрт ил задгай агаарт хог хаягдлыг шатаахаас сэргийлэх

- Агаарын тухай хуулийн 18.1-д заасны дагуу томоохон суурин эх үүсвэртэй эсэх талаар агаарын чанарын албаар дүгнэлт гаргуулах.

- Дотоод тээвэрлэлтийн замд хайрган хучилт хийх эсвэл лигнэн гэх мэт барьцалдуулагч бодис ашиглахыг зөвлөж байна.

- Зуухны галлагаагаар хийж буй дулаан хангамжийн үйл ажиллагаанд хувилбаруудаас (дулаан хангамжийн цахилгаан эх үүсвэрээр орлуулах, шинэ технологийн сэргээгдэх эх үүсвэр буюу нар салхины эх үүсвэр эсхүл байгаль орчинд халгүй эх үүсвэр буюу хийн түлшний эх үүсвэр бүхий дулаан хангамж, өөрийн суурилуулсан эх үүсвэрүүдийг утаа шүүх, хий цэвэрлэх нэмэлт багаж тоног төхөөрөмжөөр тоноглох) дан байдлаар болон хосолмол байдлаар сонгон хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авах

**2.1.1 Агаар орчны бохирдолыг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөө</b>	<b>Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар, хэмжээ</b>	<b>Нэгжийн өртөг /мян.төгрөг/</b>	<b>Хариуцах эзэн</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
Уурхайлалт, овоолго болон уурхайн замаас тоосжилт үүсэх	Уурхайн ачиж буулгах талбай орчмыг болон уурхайн замыг услах	29 900 х2л х200 хоног х 150 төг	1662,0	БОАжилтан	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0019-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшний хэмжээ
	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээ тогтмол авч байх;	Үйлдвэрийн байранд	500,0	БОАжилтан	
	Хөрс болон хүдэр тээвэрлэхдээ асгарах, тоосрохоос хамгаалсан хучлагатай байх	Үйл ажиллагааны турш	600,0	БОАжилтан	
	Уурхайн ухалт, ачилт буулгалт болон тэсэлгээний цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд		
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш	200,0		
Тоосжилт үүсэх газарт ажиллаж байгаа хүмүүс	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	ажиллагсад	600,0	Уурхайн дарга	
Уурхай дотор тэсэлгээ хийх үед	Тэсэлгээ хийх үед усан дээр ашиглах	Ил уурхайд	Шууд тооцох боломжгүй	Уурхайн дарга	
	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, замыг усалж байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ-д	Уурхайн дарга	Уурхай дотор тэсэлгээ хийх үед
<b>НИЙТ ДҮН</b>			<b>3562,0</b>		



## 2.2 Усан орчин хамгаалах арга хэмжээ

Судалгааны талбайд тогтмол урсгалтай гол горхи байхгүй. Олборлолтын явцад ил уурхайгаас шүүрлийн ус гарахгүй бөгөөд унд ахуйд болон тоосжилтийг дарах зорилгоор гүний худагаас ус авч ашиглана. Гэвч шатах тослох материалын асгаралт, ахуйн бохир усны нэвчилт зэргийн нөлөөгөөр орд орчмын хөрсний болон гүний ус бохирдох зэргээр усны чанар, нөөцөд сөрөг нөлөө учруулж болзошгүй.

Нөлөөлөлд өртөх объект:

- Газрын доорхи ус
- Хүн ам, ургамал

### *Гүний худгийг хамгаалах, тохижуулах зөвлөмж*

Уурхайн унд ахуйн болон үйлдвэрийн хэрэглээний усыг хангах гүний худагт баталгаажуулсан тоолуур суурилуулан усны хэрэглээнд хяналт тавин ажиллах шаардлагатай. /Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаал/

### **Тоолууржуулалтанд тавих ерөнхий шаардлага**

- Техникийн болон ашиглалтын баримт бичигтэй байхын зэрэгцээ загварын туршилтад орж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэмжил зүйн хяналтад хамрагдсан байх;
- Хүйтэн усны тоолуур-шалгах арга хэрэгсэл /MNS 2662:2002/ болон ундны хүйтэн ус ба халуун усны тоолуур-хэмжил зүйн болон техникийн шаардлага /MNS OIML R 49-1:2012/ стандартуудын шаардлагад нийцсэн байх;
- Хэмжил, тооцооны үнэн зөв байдлыг хангахын тулд хэрэглэгч, ашиглагчийн суурилуулах цэвэр усны тоолуурын голч нь шугам хоолойн оруулгын голчтой адил байх бөгөөд бодит зарцуулалтад тохирсон байх;
- Бохир усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь бохир усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байна.

### **Тоолуурын суурилалт**

- Газрын доорхи ус ашиглах учир ус авах цэг дээр тоолуур суурилуулна.
- Усны нэг оруулгатай учир усны тоолуурыг нэгдсэн оруулга дээр усны тоолуур суурилуулна.

### **Тоолуурын хамгаалалт**

- Усны тоолуурыг түүний заалтыг харах боломжтой, үзлэг, үйлчилгээ хийхэд тохиромжтой, гэрэлтүүлэгтэй, агаарын температур +5°C-аас багагүй дулаан өрөөнд, Ус хэмжих цахилгаан хэрэгсэл /ISO 4064/ стандартын дагуу суурилуулна.
- Тоолуур нь хөлдөлт ба механик гэмтлээс хамгаалагдсан байна.

**УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨМЖ:**

- Уурхайн усны эх үүсвэрт ашиглаж буй гүний худгийн орчны тохижилтыг хийсэн боловч “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийн шаардлагад нийцүүлэн тохижуулах, өмнө хийсэн худгийн гадна тохижилтийн ажил хангалтгүй байгааг анхаарах
- Уурхайн унд ахуйн хаягдал ус зайлуулах цэг, бие засах газрыг дахин төлөвлөх, одоо ашиглаж буй нүхэн жорлонгийн ашиглалтыг зогсоох, ариутгал халдваргүйжүүлэлт хийж бохирдлыг арилгах
- Жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, гэрээгээр ноогдуулсан ус ашиглалтын төлбөрийг бүрэн төлөх
- Усны чанар, мониторингийн ажлын хүрээнд ахуйн хаягдал бохир усны дээж авч бохир усанд тодорхойлж буй үзүүлэлтүүдээр (рН, БХХ5, гадаргуугийн идэвхт бодис, жинлэгдэх бодис гэх мэт) лабораторын шинжилгээ хийж гүйцэтгэх

**2.2 Усан орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ,багасгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
Газрын доорх усыг ашиглах	Ахуйн ус хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, усыг дахин хэрэглэх, хэмнэлттэй зарцуулах техник технологи судлах, ашиглах	Ахуйн усны хэрэглээний хүрээнд	200,0	Уурхайн дарга	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982
	Усны хэмжээ, чанарыг хянах, хяналтын цооног байгуулах; /усны эх үүсвэрийн худгууд, хаягдлын овоолго болон баяжуулах үйлдвэрийн газрын доод талд/	Газрын доорх уст үеүд	ҮАЗардалд		
Булгийн эхийг хашиж, хамгаалах	Сайн-ус багийн Дай-уулын булгийн эхийг хашиж хамгаалах,	Дай-уулын булаг	1ш шон-10к*20ш=200.0 1ш хашаа 75к*20ш=1500	Уурхайн дарга	БО, ЭМНХ-ын сайдын 1999 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоож ашиглах	Худгийн орчимд	300.0		БО, ЭМНХ-ын сайдын 1999 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
	Ус ашиглалтын гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Ахуйн усны хэрэглээ болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах хүрээнд	Үйлдвэрлэлийн усны хэмжээгээр /Умард говийн гүвээт-Халхын дун		

			сав газарт хамаарна/		
	Шатах, тослох материалын хаягдал, химийн бодисын асгаралт гаргахгүй байх;	Үйл ажиллагааны турш	300,0		
	Бороо цас үерийн ус шүүрлийн ус цуглуулах сан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх талаар судлах	Боломжт газрыг сонгох ажиллах хугацаанд	500,0		
Нийт дүн			<b>2800,0</b>		

**2.3. Хөрс, ургамал хамгаалах арга хэмжээ**

Уурхайн олборлолтод өртсөн газрын хөрс, геологийн тогтоцын эвдрэл, машин механизмын хөдөлгөөний улмаас элэгдэлд орж тоосжилт үүсэх болон машин механизмын яндангаас хаягдах хорт хий, хүнд металл зэргээр орчны хөрс, ургамал бохирдох Үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт

Хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас баталсан маягтаар гаргана. Маягтыг дээр дурдсан лабораториас авна.

**2.3 Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, багасгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгыг 2 жилээс дээш хугацаанд хадгалах тохиолдолд олон настаар ургамалжуулах;	Үйл ажилллагааны турш	2га олон наст үр тарих, 90 кг х 20.0=360,0	Уурхайн дарга	MNS 3309:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
	ТЗ талбайг тойруулан хашаа хайс хамгаалалт хийх	1,3км	ҮАЗардал	Уурхайн дарга	
	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох	Үйл ажилллагааны турш	ҮАЗардал	Уурхайн дарга	
Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	200,0	Уурхайн дарга	
	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн талбайд	300,0	Уурхайн дарга	
	Олон салаа зам гарахаас сэргийлж тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Төслийн талбайд	200,0	Уурхайн дарга	
Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	300,0	Уурхайн дарга	
	ШТМ, ТБ, химийн бодисын агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	Агуулахуудын орчимд	600,0	Уурхайн дарга	
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд	ХХМТ тусгасан		
<b>Нийт зардал</b>			<b>1960,0</b>		

**ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Тайшаншин юань” ХХК нь 2024 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөндөө ил аргаар ашиглагдах талбайд хөрс хуулалтын ажил хийх учраас техникийн нөхөн сэргээлт хийхээргүй байгаа болно. Харин туслах объект болон оффисын барилга байгууламж барих явцад эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж ургамалжуулах мод заг тарихаар төлөвлөж байна. Уурхайн талбайдаа

**2024 оны нөхөн сэргээлтийн ажлын зардал**

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (Мян.төг)	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Ил уурхайн хүрээн дэх үржил шимт хөрсийг хуулах	-	-	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн	MNS 5918:2018 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
Биологийн нөхөн сэргээлт	Уурхайг тохижуулах, тосгон болон бусад барилга байгууламж барих үед эвдэгдсэн хөрсний эвдрэлийг нөхөн сэргээх, мод тарих	0,1 га 100ш хайлаас мод уурхай дээрээ тарина.	2000,0		
Нийт дүн			<b>2000,0</b>		

Биологийн нөхөн сэргээлт хийхийн тулд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тэгшлэн, элэгдэл эвдрэлд орж дагтаршсан газрыг хагалж сийрэгжүүлсний дараа үржил шимт хөрсийг 15-20 см хучина. Үржил шимт хөрсөнд биологийн нөхөн сэргээлт хийхэд олон наст ургамалын үр, мод бут сөөгний суулгацыг 1 га-ийн норм хэмжээгээр тариална.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ашигт малтмалын болон байгаль орчны хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэс нь юм.

Үүнд:

Дараах хууль эрхийн актыг баримтлан хэрэгжүүлэх шаардлага тавигдана.

- MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5919:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- MNS 5918:2018 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага.
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага.
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО-ны болон ХААҮ-ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт)

**ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорхи хүснэгт үзүүлэв.

**4.1 Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө**

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /төг/	Хариуцах эзэн	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох;	Биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх /сонгож өгсөн талбайд/	Айраг сум	500,0	Уурхайн дарга	“Байгалийн ургамлын тухай” хуулийн 9 дугаар зүй
	Ургамлан нөмрөг нь хуулагдах болон нөлөөлөлд өртөхгүй талбайнуудыг тодорхой болгож урьдчилан хамгаалах тэмдэглэгээ сануулга байрлуулах	Төслийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн талбайд	400,0	Уурхайн дарга	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл
	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж тохирсон газарт хөрс хамгаалах, цөлжилтийн бууруулах арга хэмжээ авах	Айраг сум		Уурхайн дарга	
	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	250,0	Уурхайн дарга	
Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Нөхөн орлуулж хамгаалахаар тогтоогдсон нутагт 7,3га талбайд нөхөн сэргээлт хийлгэхээр сонгож өгсөн. Уртраг-109.27351, Өргөрөг-45.82947	Айраг сум 2-р баг 47-гийн гүүр		2024 он	

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

	Ховор, нэн ховор ургамлын тархацын талаар судлах, шаардлагатай бол шилжүүлэн суулгах	Үйл ажиллагааны турш	500,0	2024 он	
Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин нь устах идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	350,0	2024 он	
	Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	700,0	2024 он	
	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	250,0	2024 он	
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил 1ш хайлаас мод 8000,0 =800 000 төг бусад		Товлож өгсөн газарт мод тарих	1000,0	2024 он	
<b>НИЙТ ДҮН</b>			<b>3950,0</b>		

**ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд хамгийн ойр / 0,5-1км/ 2 айлын хаваржаа зуслан байх бөгөөд дээрх айлуудыг нүүлгэн шилжүүлэлт хийх асуудлыг ярилцаж гарах зардлыг “Тайшаншин юань” ХХК гаргахаар болсон ба тус өрхүүд нүүж буух газраа сонгосон зөвшөөрөл авсны дараа нүүлгэн шилжүүлэлт хийгдэхээр тохиролцоод байна. Нүүлгэн шилжүүлэлт хийх зардалд урьдчилсан байдлаар 8 000,0 мян.төг төлөвлөөд байна.

**ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

Судалгаагаар тогтоогдсон цэгүүд нь ашиглалтын лицензийн талбайд орших тул дурсгалуудын бүрэн бүтэн байдлыг ханган, газар шорооны ажилд зайлшгүй өртөх тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу авран хамгаалах малтлага судалгааг

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

зайлшгүй хийлгэх шаардлагатай ба ашиглалтын тухайн талбайд дурсгалын зүйлийг хөндөгдөхгүй байхаар уурхайн төлөвлөлтийг төлөвлөх ёстой.

**6.1 Төслийг хэрэгжүүлэх үед хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө**

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ашиглалтын талбайд байрлах 2 булш болон Айраг сум	Хайгуулын ажлаар илэрсэн Дөрвөлжин, Монгол булшуудыг хөндөхгүй үйл ажиллагааг төлөвлөх, явуулах, холбогдох байгууллагад мэдэгдэж хамгаалалтад авах, хашаа барих, тэмдэгжүүлэх	Дурсгалын зүйлс	-	500.0	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
	Түүх, соёлын өв дурсгалуудын талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох	Судалгаа хийх		ҮАЗардалд	2024 он	
	Судалгаанд ороцох	Санхүүжүүлэх	-	ҮАЗардалд	2024 он	
	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэг үзүүлэх	Санхүүжүүлэх		500,0	2024 он	
<b>НИЙТ ДҮН</b>				<b>1000.0</b>		

**ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

**7.1 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Ил уурхайд, барилга байгууламж	ҮАЗардалд	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль	Гамшгаас хамгаалах тухай хууль, 29.1



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

<b>Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх</b>		техник тоног төхөөрөмжид		орчны мэргэжилтэн хариуцна/	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Уурхайн бүх ажилчдад	500.0	Уурхайн дарга	
	Тэсэлгээний аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	500,0	Уурхайн дарга	Тэсэлгээний аюулгүй ажиллагаа
	ТБ хадгалах шилжүүлэн ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗардалд	Уурхайн дарга	
	ТБ болон химийн бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл цэвэрлэгээний материал бэлтгэж бэлэн болгох	Үйл ажиллагааны турш	250,0	Уурхайн дарга	
<b>Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	Баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийн газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Үйлдвэрийн Барилгын ажлын үед	ҮАЗардалд	Төслийн хүрээнд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн
	Осол эрсдэл үүсэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	200,0	Жил бүр	
	хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	ҮАЗардалд	Жил бүр	
<b>Нийт дун</b>			<b>1450,0</b>		

**НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд машин техникийн сольсон эд анги, дугуй зэрэг үйлдвэрийн гаралтай хог хаягдал мөн ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, хоолны газар, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн объектуудаас гарах хог хаягдлууд ордог болно.

Судалгаанаас үзэхэд уурхайд ажилладаг 1 хүнээс өдөрт дундажаар 1-1.5 кг хог хаягдал үүсдэг гэдгийг тооцвол Дай-Уулын жоншны ордын хувьд өдөрт 72 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 118,5 кг болж байна. Уурхайг жилийн 240 хоног ажиллуулна гэдгийг тооцвол жилд гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын нийт хэмжээ нь 28440,0 тн байна. Үүнийг Айраг сумын хог хаягдлын цэгт хаяж байх шаардлагатай ба төвлөрсөн цэгт хаях зөвшөөрөл буюу гэрээг сумын засаг даргатай хийхийг уурхай захиргаа хариуцсан ажиллахаар төлөвлөж байна.

Харин уурхайн ажилчдын тосгонд 72 хүн амьдарна гэж бодвол 9 хоногт 1 удаа халуун усанд орох ба норм нь 50 л/хон гэж тооцвол уурхайн ажилчид 34 долоо хоног ажиллах тул ахуйн халуун усны жилийн нийт хэрэглээ 134.3 мян м<sup>3</sup> байна. Мөн хоногт 2,96 м<sup>3</sup> ахуйн шингэн хаягдал хаягдахаар байна. Одоогийн байдлаар ил задгай бие засах газар, муу усны нүхтэй байгааг өөрчлөж “Септик”-ийн байгууламжаар дамжуулан цэвэршүүлсний дараа газрын хөрсөнд шингээж хаях нь зүйтэй.

Түүнчлэн манай орны хувьд өнөө үед ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хог хаягдлыг ангилан хоёрдогч түүхий эд материал болгон ашиглаж байгааг харгалзан түүнийг хэрэгжүүлэх боломжийг ч авч үзэх нь зүйтэй юм.

Ахуйн гаралтай хатуу хог хаягдлын бүтцийг ангилсан олон улсын жишгийг авч үзвэл доорхи байдлаар 8 хуваасан байдаг.

1. Хоол хүнсний	2. Резин, хуванцар	3. Үнс, шороо
4. Шил / Лонх	5. Мод, ургамал	6. Бусад
7. Цаас, бичиг хэргийн	8. Төмөр, металл	

Ахуйн хог хаягдалыг дээрхи байдлаар ангилсан тохиолдолд түүний шил, металл зэргийг болон машин техникийн сольсон эд анги, дугуй зэрэг үйлдвэрийн гаралтай хог хаягдлыг засварын газрын ойролцоо талбайд хурааж, төв суурин газарт тээвэрлэн хүргэж хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт нийлүүлэх арга хэмжээ авч байх.

### 8.1 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Болзошгүй нөлөөлөл	сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Хариуцах эзэн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	300,0	Уурхайн дарга	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд  Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	200,0		
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, баяжуулах үйлдвэр оффис, ШТС зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	400,0	Уурхайн дарга	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсадад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	100,0	Уурхайн дарга	
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг цэвэршүүлэх байгууламж төсөллөж хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Ажилчдын сууринд	ҮАЗардалд	Уурхайн дарга	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
<b>НИЙТ ДҮН</b>			<b>1000,0</b>		

### **Ажилчдын ариун цэвэрийн байгууламж**

Эко жорлонг Монгол улсад дагаж мөрддөг MNS 5924-2015 Стандартын дагуу хийдэг. Эко жорлонг байгаль бохирдуулагч эко бус жорлонгоос ялгаж таних хамгийн гол шинж тэмдэг бол нүх нь цэвэрлэгдэх боломжтой байх. Нүхийг хэзээ, яаж цэвэрлэх аргаа мэдэхгүй бол уг нүх хэзээ ч цэвэрлэгдэхгүй гэсэн үг. Жорлонгоо барихаас өмнө түүнийг яаж цэвэрлэхээ бодож тооцоолж, шийдсэн байх ёстой. Жорлонгийн нүхийг Монголын хүйтэн, хуурай, эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ашиглахад эвтэйхэн хэрнээ цэвэрлэгддэг байхаар хийе гэвэл дараах сонголтуудаас авч хэрэгжүүлж болно.

- 1.1. Соруулдаг
- 1.2. Газарт хуурайшуулж хатаагч
- 1.3. Саванд хуурайшуулж хатаагч
- 1.4. Газарт бордоошуулагч
- 1.5. Саванд цуглуулж бордоошуулагч

Газарт хуурайшуулж хатаагч жорлон (1.2.)

Юуны өмнө сануулж хэлэхэд, энэхүү жорлон нь зөвхөн говь, цөлөрхөг хөрстэй газарт тохиромжтой. Хөрсний чийг ихтэй нутагт хатаагчийн үүргээ гүйцэтгэж чадахгүй учир тохиромжгүй.

Газарт хуурайшуулж хатаагч жорлонгийн нүхний хэмжээ  $1\text{м}^3$ . Нүхийг дүүрсний дараа хүрэээр суллаж цэвэрлэх тул хамгийн гүнзгийдээ 150 см-ээс илүү байх нь зохимжгүй. Таван ам бүлтэй айлд ийм жорлонг дүүргэхэд дор хаяж таван жилийн хугацаа шаардлагатай. Газарт хуурайшуулж хатаагч жорлонгийн хамгийн гол элемент нь нүхний битүүмжлэл, агаарын солилцоо хоёр юм. Нүхийг аль ч талаас нь агаар, салхи, үер ус орохгүйгээр битүүмжилж, дор хаяж 11 см диаметртэй агааржуулалтын яндан суурилуулна.

Говийн халуун хөрс, гаднаас агаар үл нэвтрэх битүүмжлэл, бүдүүн яндангаар амархан уурших нөхцөл байдал нь ялгадсыг хатааж, овор багасгаж, бактер үржих орчингүй болгож өгдөг. Нүхний ёроолд зузаан элс дэвсэнэ. Энэ нь шээсийг газарт шингэхэд нь шүүлтүүр болохын зэрэгцээ өтгөнийг хатаах орчин болж өгнө. Бие засах үед хэт их шингэн ялгарсан бол жорлон руу элс, үнс, бор шороо нэмж хийн хуурайшуулж болно. Угаадас хольж болохгүй. Дүүрсний дараа жорлонгийн бүхээгийг нүүлгэж, нүхэнд био идэвхтэй бодис хийж амраана. Амарсан нүхийг 2-3 жилийн дараа султгаж дахин хэрэглэх боломжтой.

➤ *Хуурайшуулагч жорлон руу угаадас асгаж болохгүй.*

### **Агааржуулалт**

Агааржуулалтын хоолойн голч 20 см дээврийн урд хэсгээс дээш 20-30 см өндөр, хар өнгөтэй байна. Хоолойн дээд талд ялаа, шавьж барих тор, малгайвч хийнэ. Олон ажилтантай тохиолдолд салхин сэнс хийж болно. Анхаарах зүйлс:

- Бүхээгэнд Хаяавч маш чухал бөгөөд энэ нь бороо цасны ус нүхэнд орох, нүхний хана нурах, ялаа шавьж орохоос сэргийлнэ.


Нүхий урт бүхээгний уртаас 30-50 см илүү гарч байх ёстой. Учир нь

- энэхүү илүү гарсан хэсэгт агааржуулалтын хоолойн байрлаж байж нүхэн дэх бохир агаарыг зайлуулна.

Агаарын урсгалыг зөв явуулахын тулд дараах бүрдлүүд заавал байна.

1. Бүхээгний хаалга нь ноёлох салхины өөдөөс харсан чиглэлтэй
2. Хаалганы дээд талд 40 см х 20 см-ээс багагүй хэмжээтэй тортой цонх
3. Бие засах нүх 38 см х 25 см-ээс багагүй хэмжээтэй тагтай
4. Агааржуулалтын хоолойн ёроол нүхэнд 10 см орсон дээврийн хамгийн өндөр хэсгээс дээш 20-30 см өндөрт байх
5. Агааржуулалтын хоолойн дээр ялааны тор, малгайвч байх

Нүхэн жорлон болон бохирын цооногт кальцийн гипохлорид 40%-тайг хэрэглэх.



Зураг. Эко жорлон

### НҮХЭН ЖОРЛОНД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ЗӨВЛӨМЖ

Шар усны үерийн үед гарч болох халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нүхэн жорлонгийн бохиороор дамжих халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд энэхүү зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Халдваргүйжүүлэлтэнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан хлорлог бодисыг хэрэглэнэ.

#### Хлорлог бодисыг ашиглан халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх:

Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэхийн өмнө хлорын идэвхийг тодорхойлно. Иргэд өөрсдөө халдваргүйтгэл хийх бодисоо худалдан авахдаа идэвхитэй хлорын хэмжээг тодорхойлсон шинжилгээний дүнг мэдэж авах нь чухал.

**Дараах томъёог ашиглан уусмал бэлтгэхэд шаардлагатай бодисын хэмжээг тооцон гаргана**

Бэлтгэх уусмалын% / хлорын идэвх% x 1000= 1л ус тутамд хийх бодисын хэмжээ /гр/

Жишээ: 40%-ийн идэвхтэй кальцийн гипохлорит 0.5%-ийн 1 л уусмал бэлтгэхэд хичнээн хэмжээний бодис авахыг тооцож үзье.

$$m = 0.5\% / 40\% \times 1000 = 12.5 \text{ грамм}$$

12.5 грамм бодис жинлэн авч 1 литр усанд уусган хэрэглэнэ.

**АНХААР:** Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх усны температур 30-40 градус байх нь тохиромжтой.

Хуурай бодисоос халдваргүйжүүлэх уусмал бэлтгэсэн тохиолдолд уусаагүй хэсгийг тунгаах зорилгоор 30 минут байлгаж хэрэглэнэ

**Хэрэглэх арга:**

Халдваргүйжүүлэлтийн уусмалыг 1 м<sup>3</sup> талбайд 2 литр уусмал орохоор тооцож, нүхэн жорлон, бохирын цооногийн эзлэхүүнд тохируулан уусмалаа бэлтгэнэ. Халдваргүйжүүлэлт хийсний дараа 1-2 цаг нүхэн жорлонгийн хаалгыг хааж, бохирын цооногийг таглана.

Гэр хорооллын нүхэн жорлон, бохирын цооногт дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд гурван сард нэг удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

Хана, тааз, гишгүүрийг шүршиж халдваргүйжүүлнэ.

**Аюулгүй ажиллагаа:**

Халдваргүйжүүлэлтийн бодисыг найруулах хэрэглэхийн өмнө зааврыг сайтар унших, зааврын дагуу найруулана.

Уусмал бэлтгэхдээ хамгаалах өмсгөл, бээлий маск, нүдний шил хэрэглэнэ.

Санамсаргүй тохиолдлоор хуурай бодис, бургиж нүд рүү орсон бол урсгал, бүлээн усаар сайтар угаах, амьсгалын замаар орсон бол цэвэр агаарт гаргах шаардлагатай.

➤ **Найруулсан уусмалыг тухайн өдөртөө хэрэглэнэ.**

➤ **Хуурайгаар хэрэглэхийг хориглоно.**

## **ЁС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг үйлдвэрлэлийн ерөнхий инженер хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.
- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгнө.
- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүн, аваар ослын тайлан уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл зэргийг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, тайлагнаж байх.
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1-2 удаа сургаж, дадлагажуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах.
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

**9.1 Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө**

<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Хугацаа</b>	<b>Зардал мян.төгрөг</b>	<b>Хариуцах эзэн</b>
Байгаль орчны асуудлыг хариуцсан мэргэжилтний түр орон тоог бий болгон уурхайн даргын хяналт доор ажиллуулах	2024 он	Дотоод зохион байгуулалтаар	Уурхайн дарга
Нийт уурхайчдыг байгаль орчныг хамгаалах талаар жил бүрийн сургалтад хамруулах	2024 он	350	Уурхайн дарга
Ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жил бүр	25.0 * 72 хүн=1800.0	
Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах	2024 он	Гэрээгээр зохицуулах	Уурхайн дарга
Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй хориотой зурвасыг хамгаалсан болон тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг шинэчилэн сайжруулах	2024 он	10ш*10=100	Уурхайн дарга
Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	2024 он	Дотоод зохион байгуулалтаар	Уурхайн дарга
Өрөмдлөг тэсэлгээний паспорт хөдлөх	2024 он	Дотоод зохион байгуулалтаар	Уурхайн дарга
	<b>Дүн</b>	<b>2250.0</b>	

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Аймгийн байгаль орчин аялал жуулчлаын газраас	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дүгнэлт хавсаргах	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

**2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 25972,0 мян.төг байна.**

**11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Агаарын чанар</b>						
1.1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Баяжуулах үйлдвэр болон хаягдлын далангаас уурших	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд А1, А2	Улирал тутамд	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 2 удаа НИЙТ 80.0	MNS 4585:2009 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0019-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга,
1.2	Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Хөрсний овоолго хүдрийн овоолго А3, А4	Улирал тутамд	Шинжилгээний зардал: 1 удаагийн х 50.0 х өдөрт 2 удаа х 2 цэг х жилд 2 удаа НИЙТ 400.0	

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, 2 цэгт А5, А6	Улирал тутамд	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2 удаа НИЙТ 60.0	MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
<b>Усны хяналт шинжилгээ</b>						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Технологийн хаягдал усаар усан орчин ба хөрс бохирдох	Унд ахуйн усыг хангаж буй гүний худаг худаг-1 Худаг -2	Жилд 2 удаа	46.0*2 удаа НИЙТ 92.0	MNS (ISO) 4869:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5669-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Усны түвшин усны ундарга нөөц.	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорхи усны горим өөрчлөгдөх	Ашиглалтын худагууд, ойролцоох малчдын худагууд хяналтын цооног	2 Улирал тутам	Багажийн түрээсийн зардал: багаж 200.0 х жилд 2 удаа НИЙТ 400.0	
<b>Хөрсний бохирдол</b>						
3.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох Нөлөөлөлд өртөөгүй болон хөрс овоолго хийгдсэн талбай, шимт хөрсний овоолго дээр Х-1, Х-2	Хагас жилд тутам	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х/20.0 НИЙТ 160,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -20.0 төг,	MNS 3309:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3695:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1989 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАЙ-УУЛ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	Хүнд металлын (Pb, Cd, Zn, As, Sr, Ni) агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох		жилд 1 удаа	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 45,0 Нийт 180,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 45.0 төг/	MNS ISO 11049:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3695:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамлын аймаг						
4.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2цэгт (Ур-1; Ур-2)	Жилд 1 удаа	500,0	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
<b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖИЛИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>					<b>1892.0</b>	